



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017. 03.15 № 3/461
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээний, өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

“Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ын гүйцэтгэх удирдлага нь тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (НББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг хариуцлага хүлээнэ.

“Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.


Аудитаар “Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ын санхүүгийн тайлан болон тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлт, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан болно.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

"Геологийн төв лаборатори" ТӨҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон санхүүгийн тайлангийн тодруулгуудыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлж Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**“ГЕОЛОГИЙН ТӨВ ЛАБОРАТОРИ”ТӨҮГ- ЫН
2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
АУДИТ**

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах
хаягаар харилцана уу:**

Аудитын тайлан

САГ-ын дарга
Тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас:261663
Цахим хаяг:
naranchimegts@audit.gov.mn

Хавсралт 1: Агуулга
Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
Хавсралт3: Менежментийн захидал
Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
Хавсралт 5: Аудит хийсэн зорилтот
түвшингийн гүйцэтгэлийн тайлан

Аудитын менежер: Я.Самбууням

Аудитор: Ж.Болормаа
Утас: 261885
Цахимхаяг: Bolormaaj@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: Үндэсний аудитын газар
Байршил: Чингэлтэй дүүрэг 3Г-н 4-р байр
Цахим хуудас: www.audit.mn

2017 оны 3 дугаар сарын 09

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго,үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллаг байдлын түвшин
6. Дотоод хяналт
7. Бизнес төлөвлөгөөний биелэлт, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Зөвлөмж
18. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

1.Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8,Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /САГ-2017/29/СТА -ТӨҮГ/ аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/ түүнд нийцүүлсэн нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Байгууллагын удирдлага санхүүгийн тайланг СТОУС түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 02 дүгээр сарын 22-оос эхлэн хуулийн хугацаанд хийхээр төлөвлөн “Цэгцтөв богд аудит” ХХК-ийн 2 дугаар багийн аудитор Д.Өлзий-Орших аудиторын туслах ажилтан Х.Хонгорзул нар хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

“Геологийн төв лаборатори” ТӨҮГ 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 161 тоот албан бичгээр “Цэгцтөв богд аудит” ХХК-д ирүүлсэн байна.

“Цэгцтөв богд аудит” ХХК аудитыг 2017 оны 02 дүгээр сарын 22-оос эхлэн гүйцэтгэж, аудитын тайланг хуулийн хугацаанд “Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ын удирдлагад гардуулна.

2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин

“Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ын удирдлага нь Монгол улсын “Иргэний хууль”, “Ашигт малтмалын тухай”, “Цөмийн энергийн тухай”, “Стандартчилал тохирлын үнэлгээний тухай”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай”, “Хөдөлмөрийн тухай”, “Төрийн аудитын тухай”, “Нийгмийн даатгалын тухай”, “ХХОАТ-ын тухай”, “ААНОАТ-ын тухай”, “НӨАТ-ын тухай”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай”, “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай”, “Шилэн дансны тухай” хуулиуд болон эдгээр хуулиудтай нийцүүлэн

гаргасан Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаал, бусад холбогдох эрх зүйн актуудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

“Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ын зорилт нь Монгол улсын эрдсийн түүхий эдийн шинжилгээний үнэн зөв баталгаатай үр дүнгээр захиалагч, үйлчлүүлэгчийг хангахад оршино.

“Геологийн төв лаборатори” ТӨҮГ нь чиг үүргээ хэрэгжүүлэхээр захиалагчийн хөрөнгөөр дараах үйл ажиллагааг явуулдаг.

- Эрдсийн түүхий эд, тэдгээрийн баяжмалд элементийн болон эрдсийн найрлага, бүтцийг хими, спектор, минералоги, петрограф, минераграф цөмийн физикийн тоон, хагас тоон болон чанарын шинжилгээг дэвшилтэт арга техник, технологи ашиглан захиалагчийн эрэлт шаардлагад нийцүүлэн өндөр нарийвчлалтайгаар тодорхойлох,
- Ашигт малтмалын дээжийн физик, механик шинж чанар, үзүүлэлтүүдийг тодорхойлох шинжилгээ судалгааны ажил гүйцэтгэх,
- Эрдсийн түүхий эд, цацраг идэвхит ашигт малтмал бусад боломжит материалаар холбогдох стандартад нийцүүлэн захиалагчийн болон өөрийн хөрөнгөөр аттестатчилсан стандартчилсан загвар зохион бүтээх, баталгаажуулах, дотоод гадаадын зах зээлд борлуулах,
- Эрх бүхий төрийн захиргааны байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр аж ахуйн нэгжүүдийн ашигт малтмалын олборлолтын явцад хяналтын сорьцлолт, шинжилгээ хийж дүгнэлт зөвлөмж өгөх
- Эрдсийн түүхий эдийн шинжилгээ хийж байгаа лабораториудын шинжилгээний ажилд хяналтын шинжилгээг хийх,
- Бараа бүтээгдэхүүний чанарын баталгаажуулалтын сорилт шинжилгээ хийх, хөндлөнгийн хяналт буюу итгэмжлэгдсэн лабораторийн үүргийг гүйцэтгэх, Лабораторийн шинжилгээний дэвшилтэт арга аргачлал боловсруулж батлуулах,
- Төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлэгч болон тохируулагч агентлагийн шугамаар хэлэлцэгдэн дэмжигдсэн гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрт хамтран болон бие даан оролцох,
- Лабораторийн шинжилгээ туршилтад нэвтэрч байгаа дэлхийн улс орнуудын дэвшилтэт аргачлал, техник, технологийг нэвтрүүлэх, сургалт зохион
- байгуулах чиглэлээр гадаад, дотоодын эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран ажиллах,

“Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ын өмчлөгч нь төр байх бөгөөд төрийн захиргааны төв байгууллагаас салбарын хэмжээнд баримталж буй бодлогыг удирдлага болгон ажиллана.

2016 оны зорилтот түвшингийн төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Төрийн өмчийн хорооны 2015 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн баталсан боловч хурлын шийдвэрийг албажуулан гаргаж

тус үйлдвэрт ирүүлээгүй байна. ТӨҮГ-ын үйл ажиллагаатай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судлан байгууллагын хууль, эрх зүйн орчин хэсэгт харуулав.

“Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 45-ыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад “Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг СТОУС, нягтлан бодох бүртгэлийн программ хангамжинд нийцүүлэн боловсруулж байгаа бөгөөд баталж мөрдөж эхлээгүй байна.

“Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

“Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаа бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүү, нягтлан бодох бүртгэлийн “Даймонд-5” программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг бэлтгэсэн байна. Программ нь “excel” программ руу хөрвүүлэх боломжтой, ойлгомжтой алдаа гарах магадлал багатай байлаа.

5. Материаллаг байдлын түвшин

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг нийт орлогын 1 хувиар тогтоож, хүлээн зөвшөөрөх алдааны түвшинг 28,129.0 мянган төгрөг гэж тооцов.

Тус байгууллага өөрийн эзэмшиж байгаа эд хөрөнгийн хэмжээгээр эрх эдэлж, хариуцлага хүлээдэг, аж ахуйн тооцооны зарчмаар орлогоороо зардлаа нөхөж ажилладаг учир нийт орлогын нэг хувиар материаллаг байдлын түвшинг тогтоох нь зохимжтой гэж үзлээ.

6. Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ын санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийн бичилт, журналыг санхүүгийн баримттай тулгах байдлаар аудит хийх явцад материаллаг хэмжээний зөрүүгүй байлаа. Энэ нь санхүүгийн үйл ажиллагаа стандартын шаардлагыг хангаж байгааг харуулж байна гэж үзлээ.

7. Зорилтот түвшингийн төлөвлөгөөний биелэлт, түүний талаарх тайлбар

2016 оны зорилтот түвшингийн төлөвлөгөөний дагуу, арилжааны банкин дахь харилцах дансаар болон байгууллагын мөнгөн кассаар дамжуулан санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлж, батлагдсан зардлыг өөрийн төсөвлөсөн зүйл ангиар зарцуулж, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажилласан байна.

“Геологийн төв лаборатори” ТӨҮГ нь 2016 онд өөрийн үйл ажиллагааны орлого 2,794.2 сая төгрөг, түрээсийн болон хүүний гэх мэт бусад орлогоор 23.4 сая төгрөг, нийт 2,817.6 сая төгрөгийн орлогоос Борлуулсан бүтээгдэхүүний өртөг 3,018.3 сая төгрөг, урсгал зардалд 645.9 сая төгрөгийг зарцуулж, валютын ханшийн хэрэгжсэн олз 1.3 сая төгрөг 845.3 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

8. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийг 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна. Энэхүү хуулийн зорилт нь улс орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор, төсвийн удирдлагын хэрэгжүүлж байгаа шийдвэр үйл ажиллагааг ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэхэд оршино гэж заасан байна.

Засгийн газрын 2014 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 394-р тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох” тухай журам батлагдсаны дагуу “Геологийн төв лаборатори” нь “Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар авах арга хэмжээний тухай” Захирлын 248 тоот тушаалаар зохицуулан байгууллагын вэб сайтад шилэн дансаа нээж цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн нэгтгэсэн мэдээллийг, зорилтот түвшний гүйцэтгэлийг 3-р улирлыг дуустал, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтыг 8-р сар хүртэл, эхний хагас жилийн санхүүгийн тайлан, овердрафт зээлийн гэрээ, батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт зэргийг шивж оруулсан байна.

9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу 14-н дансанд эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд 40 ширхэг хяналтын болон нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Аудитын гүйцэтгэлээр төлөвлөлтийн үе шатанд үр нөлөөтэй гэж авч үзсэн эрсдлүүдээс бараа материал, авлага, өглөг данс, зардлын дансны гүйлгээтэй холбоотой дараах зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

10. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар

“Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, цалин хөлс, бараа материал, тээвэр шатахуун, бичиг хэрэг, хангамжийн материал, авлага, өглөг зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлого, зардал, хөрөнгийн 70 хувийг эзэлж байна. Тайлангийн хугацаанд гол онцлог гүйлгээ нь ажиллагсдын цалинг хэвийн олгох зорилгоор Голомт банкнаас авсан овердрафт зээл, хөгжлийн банкнаас шинжилгээний тоног төхөөрөмж бэлтгэхээр авсан урт хугацаат зээлүүд нь өглөг нэмэгдүүлэх үндэс болж байна.

Авлага өглөгийн харьцаа алдагдаж авлагаас өглөгийн үлдэгдэл давсан үзүүлэлттэй байна. Мөн нэг жилээс дээш хугацаатай насжилт өндөртэй авлагын дүн 749.9 сая төгрөг болж найдваргүй авлага үүсэх эрсдэл өндөртэй болсон байна. Өмнөх оноос авлагын үлдэгдэл 213.4 сая төгрөгөөр буурсан байгаа ч өглөгийн үлдэгдэл 310.6 сая төгрөгөөр нэмэгдэж санхүүгийн чадвар буурсан байна. Байгууллагын боловсруулсан Зорилтот түвшингийн төлөвлөгөөний нийт зардал 195.6 сая төгрөгөөр, үүний дотор удирдлагын зардал 86.8 сая төгрөгөөр хэтэрсэн байна.

11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Авлага дансанд бүртгэлтэй 411 харилцагчидтай холбогдох 1,008.1 сая төгрөгийн авлага тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй, үүнээс насжилт ихтэй 13 сараас дээш хугацааны авлага 749.9 сая төгрөг байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулах, баримтжуулах ажлыг зохион байгуулах удирдах” гэсэн заалтыг хэрэгжүүлж, зөрчлийг таслан зогсоох, авлагыг барагдуулахаар албан шаардлага өгөв.

2. Дансны өглөгөөр бүртгэсэн 125 харилцагчидтай холбоотой 898.7 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байгаа нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулах, баримтжуулах ажлыг зохион байгуулах удирдах” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах, өглөгийг барагдуулах, зөрчлийг таслан зогсоох албан шаардлага өгөв.

3. Санхүүгийн байдлын тайланд НӨАТ-ын өглөгийн үлдэгдэл 337,201.6 мянган төгрөг байхад татварын тайланд 388,235.2 мянган төгрөгөөр тайлагнаж зөрүү 51,033.6 мянган төгрөг үүссэн нь санхүүгийн тайлангийн “үнэн зөв” батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулах, баримтжуулах ажлыг зохион байгуулах удирдах” гэсэн заалтын дагуу тооцоо нийлж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлд “Нягтлан бодох бүртгэлийн алдааг залруулах” гэсэн заалтаар залруулах зөвлөмж өгөв.

4. Төрийн өөрийн өмчийг түрээслүүлсний орлогын 20 хувийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын төрийн сан дахь дансанд төвлөрүүлээгүй нь Монгол улсын засгийн гарын 2001 оны 134 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслэх журмын 2.17-д “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар төвлөрүүлж улсын төвлөрсөн төсөвт оруулна.” гэсэн заалтыг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн өмчийн байр түрээслүүлсний орлогын 20 хувь болох 2,433.600.00 төгрөгийг төрийн сангийн дансанд төвлөрүүлэхээр акт тогтоов.

5. Жилийн эцсийн санхүүгийн тайланг 2017 оны 2 дугаар сарын 21-ны өдрийн 161 тоот албан бичгээр ирүүлсэн нь Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 дэх заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 8.9.8-д “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн

этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” гэснийг мөрдөж ажиллах зөвлөмж өгөв.

12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Санхүүгийн тайлангийн аудитаар дараах материаллаг бус алдааг залруулаагүй болно Үүнд:

1. Авлага өглөгийн үлдэгдэлд валютын ханшийн зөрүү тооцоолоогүйн улмаас авлага дансны үлдэгдэлд 1.8 сая төгрөг, өглөг дансны үлдэгдэлд 1.9 сая төгрөгийн ханшийн бодит бус ашиг гарсан нь санхүүгийн тайлангийн “үнэн зөв” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийг хөтлөх зааврыг үндэслэн Монгол банкны 12 сарын 31-ний өдрийн хаалтын ханшаар валютын ханшийн бодит бус ашиг тооцож санхүүгийн болон орлогын албан татварын тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай 15 дугаар зүйлд “Нягтлан бодох бүртгэлийн алдааг залруулах” гэж заасны дагуу залруулга хийх зөвлөмж өгөв.

2. Дахин үнэлгээ хийгдсэн хөрөнгийн үлдэгдлийн тооцоо бодсон акт байхгүй нь санхүүгийн тайлангийн “үнэн зөв” батламж мэдэгдэл хангагдахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дахин үнэлгээний материалд тулгуурлан уг хөрөнгийн үлдэгдлийг тооллогын бүртгэлтэй тулгаж баталгаажуулах зөвлөмж өгөв. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлд зааснаар залруулах зөвлөмж өгөв.

13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал

“Геологийн төв лаборатори” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2016 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас хийсэн баримтын хяналт шалгалтаар тус лабораторийн үйлдвэрлэсэн чулуун бэлэн бүтээгдэхүүн, сувинер, бичгийн хэрэгсэл, чулуун шагай, чулуун хайрцаг, мөнгөн эмжээр, чулуун жааз гэх мэт нийт 54.3 сая төгрөгийн эд хөрөнгийг хурал зөвлөгөөн, гадны уулзалт, үзэсгэлэн, гадаад томилолт зэрэг арга хэмжээнд зориулан бэлэглэсэн нь “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 30 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө оруулахыг хориглоно” гэж заасныг зөрчсөнийг цаашид гаргахгүй байх, шаардлагатай тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл авах зөвлөмж өгсөн байна.

14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

“Геологийн төв лаборатори”-ийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

“Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд материаллаг бус хэмжээний нийт 6.1 сая төгрөгийн алдаа зөрчил гарсныг дахин давтагдахгүй байхаар зөвлөмж өгч Менежментийн захидлаар байгууллагын удирдлагад хүргүүлэв.

16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

“Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ын 2015 оны санхүүгийн тайлангийн аудитыг “Цэгцтөв богд аудит” ХХК хийж 4 зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмж аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлангаар гарсан алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцох зөвлөмж хэрэгжээгүй, авлага барагдуулах ажлын хэрэгжилт хангалтгүй байна.

17. Зөрчилгүй санал дүгнэлт

“Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ын үйл ажиллагааны 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон зорилтот түвшингийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 6 хуудас, хавсралтууд 4 хуудсыг тус тус хавсаргав.

“ГЕОЛОГИЙН ТӨВ ЛАБОРАТОРИ”- ТӨҮГ- ИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1	
Авлагын талаар.....	1
Асуудал 2	
Өглөгийн талаар.....	2
Асуудал 3	
Гадаад валютын ханшийн зөрүүгийн талаар.....	3
Асуудал 4	
Санхүүгийн тайлангийн зөрүүний талаар.....	4
Асуудал 5	
Төрийн өөрийн өмчийн түрээсийн талаар.....	5
Асуудал 6	
Хөрөнгийн дахин үнэлгээний талаар.....	6
Асуудал 7	
Санхүүгийн тайлангийн цагалбарын талаар.....	7

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг “Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгдсэн ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ын санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Авлагын талаар:**Тэргүүлэх ач холбогдол №1*****Аудитын ажиглалт***

1.1 Авлага дансанд бүртгэлтэй 411 харилцагчидтай холбогдох 1,008.1 сая төгрөгийн авлага тооцоо нийлсэн актаар баталгаажуагүй, үүнээс насжилт ихтэй 13 сараас дээш хугацааны авлага 749.9 сая төгрөг байна.

Эрсдэлүүд

Найдваргүй авлага үүсэх, алдагдал хүлээх эрсдэлтэй / ҮЗ /

Аудитын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулах, баримтжуулах ажлыг зохион байгуулах удирдах” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах, авлагыг барагдуулах албан шаардлага

Төсвийн захирагчийн хариу**Асуудал 2: Өглөгийн талаар:****Тэргүүлэх ач холбогдол №2*****Аудитын ажиглалт***

2.1 Дансны өглөгөөр бүртгэсэн 125 харилцагчидтай холбоотой 898.7 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна.

Эрсдэлүүд

Өр төлбөр нэмэгдэх, санхүүгийн чадвар алдагдах /ҮЗ /

Аудитын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулах, баримтжуулах ажлыг зохион байгуулах удирдах” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах, авлагыг барагдуулах

Төсвийн захирагчийн хариу**Асуудал 3: Санхүүгийн тайлангийн талаар:****Тэргүүлэх ач холбогдол №3**

Аудитын ажиглалт

3.1 Гадаад валютаар илэрхийлэгдсэн 0.7 сая ам долларын авлагыг тухайн үеийн ханшаар тооцож 16.9 төгрөгөөр санхүүгийн тайланд тусгасан Монгол банкны 12 сарын 31-ний өдрийн хаалтын ханшаар тооцоход 18.7 сая төгрөг болж зөрүү нь 1.8 сая төгрөг, 4.1 сая ам.долларын өглөгийг тухайн үеийн ханшаар тооцож 8.4 сая төгрөгөөр санхүүгийн тайланд тусгасныг жилийн эцсийн ханшаар тооцоход 10.2 сая төгрөг болж 1.9 сая төгрөгийн ханшийн зөрүү үүссэн нь санхүүгийн тайлангийн “үнэн зөв” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнагдаагүй байх. /ҮЗ/

Аудитын зөвлөмж

НББОУС 21-ийн 11-д "гадаад валютын дүн тайлант хугацааны эцэст ашиглаж байгаа ханшийг үргэлж тусгаж байх ёстой" гэснийг баримтлан 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн Монгол банкны ханшаар тооцож санхүүгийн тайланд залруулга хийж бүртгэлд тусгах

Төсвийн захирагчийн хариу

Асуудал 4: Татварын тооцооллын талаар

Аудитын ажиглалт

4.1 Санхүүгийн байдлын тайланд НӨАТ-ын өглөг 337,201.6 мянган төгрөг байхад НӨАТ-ын тайланд 388,235.2 мянган төгрөгөөр тусгаж зөрүү 51,033.6 мянган төгрөгийн зөрүү үүссэн нь байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнагдаагүй байх. /ЭҮ, ҮЗ/

Асуудал 5: Хөрөнгийн дахин үнэлгээний талаар:

Аудитын ажиглалт

5.1 Дахин үнэлгээ хийгдсэн хөрөнгийн үлдэгдэл бодитой эсэх нь тодорхой бус байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнагдаагүй байх. /ЭҮ, ҮЗ/

Тэргүүлэх ач холбогдол № 4

Аудитын зөвлөмж

НББ-ийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна. 15.2-т НББ-ийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсний дагуу НӨАТ-ын тооцоог нийлж актаар баталгаажуулах зөрүүг залруулах.

Төсвийн захирагчийн хариу

Тэргүүлэх ач холбогдол № 5

Аудитын зөвлөмж

Дахин үнэлгээ хийгдсэн хөрөнгийн бүртгэлийг үндэслэн үлдэгдлийг тулган баталгаажуулах.

Төсвийн захирагчийн хариу

Асуудал 6: Санхүүгийн тайлангийн цагалбар хугацааны талаар

Тэргүүлэх ач холбогдол № 6

Аудитын ажиглалт

6.1 Санхүүгийн тайланг 2017 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн 161 тоот албан бичгээр аудит хийлгэхээр ирүүлсэн нь Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д "Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайланд аудит хийгдэх хугацаа алдагдах, хуулийн хэрэгжилт хангагдахгүй байх /ЭҮ/

Аудитын зөвлөмж

Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д "Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх" гэсэн хуулийн заалтыг хэрэгжүүлэн хугацааг баримтлан ажиллах.

Төсвийн захирагчийн хариу

АУДИТ ХИЙГДСЭН ҮЛДЭГДЭЛ БАЛАНС

СТ-1

"ГЕОЛОГИЙН ТӨВ ЛАБОРАТОРИ" ТӨҮГ			
(Байгууллагын нэр)		(төгрөгөөр)	
Балансын зүйл	Үлдэгдэл		
	01 дүгээр сарын 01	12 дугаар сарын 31	
А.Хөрөнгө			
1. Эргэлтийн хөрөнгө			
Мөнгөн хөрөнгө	23,946,327.73	13,038,615.98	
Дансны авлага	1,142,427,957.08	1,408,060,754.00	
Бусад авлага			
Бэлэн бүтээгдэхүүн			
БМҮБЗүйлс	1,111,426,596.93	1,347,148,086.59	
ТЭМ			
Хангамжийн материал			
Богино хугацаат хөрөнгө оруулалт			
Дуусаагүй үйлдвэрлэл			
Зээлийн эрсдэлийн сан			
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	20,450,971.75	2,785,863.75	
<u>Эргэлтийн хөрөнгийн дүн</u>	<u>2,298,251,853.49</u>	<u>2,771,033,320.32</u>	
2.Эргэлтийн бус хөрөнгө			
Биет хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	4,984,647,830.13	4,806,457,529.58	
Хуримтлагдсан элэгдэл	12,843,680.00	12,843,680.00	
Бусад үндсэн хөрөнгө			
Хуримтлагдсан элэгдэл			
Биет бус хөрөнгө			
Хуримтлагдсан элэгдэл			
Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө			
Хуримтлагдсан элэгдэл			
Дуусаагүй барилга			
<u>Биет хөрөнгийн дүн</u>	<u>4,997,491,510.13</u>	<u>4,819,301,209.58</u>	
Биет бус хөрөнгө			
Патент			
Зохиогчийн эрх			
Бусад			
Биет бус хөрөнгийн элэгдэл			
<u>Биет бус хөрөнгийн дүн</u>	<u>-</u>	<u>-</u>	
Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө			
<u>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</u>	<u>4,997,491,510.13</u>	<u>4,819,301,209.58</u>	
<u>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</u>	<u>7,295,743,363.62</u>	<u>7,590,334,529.90</u>	

Б.Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч

1. Өр төлбөр

Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	130,146,694.83	306,191,610.36
Цалингийн өглөг		91,533,872.10
Татварын өглөг	127,256,233.76	278,476,439.11
ХХОАТ-ын өглөг		
НӨАТ-ын өглөг		
ЭМНДШ-ийн өглөг	22,466,370.02	103,882,932.92
Банкны богино хугацаат зээл		
Бусад богино хугацаат өр төлбөр	290,000.00	290,000.00
УОО	246,048,779.89	251,782,583.89
Түрээсийн өглөг/ бусад татварын өглөг/		
<u>Богино хугацаат өр төлбөрийн дүн</u>	<u>526,208,078.50</u>	<u>1,032,157,438.38</u>
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат бондын өглөг		
Урт хугацаат зээлийн өглөг	342,900,000.00	223,900,000.00
Бусад урт хугацаат өглөг		
Урт хугацаат өглөгийн хасагдуулга		
<u>Урт хугацаат өр төлбөрийн дүн</u>	<u>342,900,000.00</u>	<u>223,900,000.00</u>
<u>Нийт өр төлбөрийн дүн</u>	<u>869,108,078.50</u>	<u>1,256,057,438.38</u>
2. Эзэмшигчдийн өмч		
Өмч: а.төрийн	3,413,613,163.67	3,413,613,163.67
б.хувийн		
Хөрөнгийн дахин үнэлгээний хэсэг	773,675,947.28	773,675,947.28
<u>Цэвэр өмчийн дүн</u>	<u>4,187,289,110.95</u>	<u>4,187,289,110.95</u>
Дахин үнэлгээний өөрчлөлт		
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	878,158,426.75	1,101,172,859.27
Хуримтлагдсан ашиг /алдагдал/	1,361,187,747.42	1,045,815,121.30
Тайлант хугацааны ашиг /алдагдал		
Өмнөх үеийн		
<u>Эзэмшигчдийн өмчийн дүн</u>	<u>6,426,635,285.12</u>	<u>6,334,277,091.52</u>
<u>ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН</u>	<u>7,295,743,363.62</u>	<u>7,590,334,529.90</u>

АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ТАЙЛАН

СТ-2

"ГЕОЛОГИЙН ТӨВ ЛАБОРАТОРИ" ТӨҮГ

(Байгууллагын нэр)		(төгрөгөөр)	
ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн	
1. Нийт орлого	3,125,775,059.27	2,923,349,775.71	
<u>Борлуулалтын хөнгөлөлт</u>			
<u>Борлуулалтын орлогын дүн</u>	3,125,775,059.27	2,923,349,775.71	
2. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	2,760,047,040.99	2,810,427,421.93	
3. Нийт ашиг	365,728,018.28	112,922,353.78	
4. Түрээсийн орлого	18,096,000.00	18,603,000.00	
5. Хүүгийн орлого	90,907.98	217,441.60	
6. Борлуулалт маркетингийн зардал	28,010,916.24	72,477,428.99	
7. Үйл ажиллагаа (борлуулалт) ерөнхий удирдлагын зардал	234,782,310.66	276,807,934.82	
8. Бусад зардал	39,529,249.83	111,208,649.31	
9. Гадаад валютын ханшийн зөрүүний олз /гарз	912,467.50	(1,999,664.22)	
10. Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз/гарз	(475,020.25)	15,400,000.00	
11. Үйл ажиллагааны бус орлого			
12. Үйл ажиллагааны бус зарлага			
13. <u>Ердийн үйл ажиллагааны ашиг алдагдал</u>	82,029,896.78	(315,350,881.96)	
14. Онцгой шинжтэй орлого			
15. Онцгой шинжтэй зарлага			
16. Хамсаа болон хамтарсан үйлдвэрээс орсон орлого			
17. <u>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</u>	82,029,896.78	(315,350,881.96)	
18. <u>Орлогын татварын зардал</u>	12,038,519.23	21,744.16	
19. <u>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</u>	69,991,377.55	(315,372,626.12)	

АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

СТЗ

"ГЕОЛОГИЙН ТӨВ ЛАБОРАТОРИ" ТӨҮГ

(Байгууллагын нэр)

(төгрөгөөс)

Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютин хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<u>2013.12.31 Эцсийн үлдэгдэл</u>	3,413,613,163.67	-	-	773,675,947.28	-	825,079,366.96	1,394,715,389.87	6,407,083,867.
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	3,413,613,163.67	-	-	773,675,947.28	-	825,079,366.96	1,394,715,389.87	6,407,083,867.
Тайлант үеийн цэвэр ашиг/алдагдал	-	-	-	-	-	-	-	-
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	53,079,059.79	-	53,079,059.
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-	(103,519,020.00)	(103,519,020.
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-	-	69,991,377.55	69,991,377.
<u>2014.12.31 Эхний үлдэгдэл</u>	3,413,613,163.67	-	-	773,675,947.28	-	878,158,426.75	1,361,187,747.42	6,426,635,285.
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	3,413,613,163.67	-	-	773,675,947.28	-	878,158,426.75	1,361,187,747.42	6,426,635,285.
Тайлант үеийн цэвэр ашиг/алдагдал	-	-	-	-	-	-	(315,372,626.12)	(315,372,626.
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	223,014,432.52	-	223,014,432.
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-	-	-	-
<u>2015.12.31 Эцсийн үлдэгдэл</u>	3,413,613,163.67	-	-	773,675,947.28	-	1,101,172,859.27	1,045,815,121.30	6,334,277,091.

"ГЕОЛОГИЙН ТӨВ ЛАБОРАТОРИ" ТӨҮГ		
(Байгууллагын нэр)		(төгрөгөөр)
Үзүүлэлт	Үлдэгдэл	
	01 дүгээр сарын 01	12 дугаар сарын 31
1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
<u>1.1 Мөнгөн орлогын дүн</u>	<u>3,257,974,971.06</u>	<u>2,941,149,773.45</u>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	3,255,810,271.06	2,940,449,373.45
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	2,164,700.00	700,400.00
Буцаан авсан албан татвар		
Бусад мөнгөн орлого		
<u>1.2 Мөнгөн зарлагын дүн</u>	<u>(3,041,684,012.75)</u>	<u>(2,831,032,762.58)</u>
Ажилчдад төлсөн	(1,267,098,975.57)	(1,289,572,146.05)
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(367,224,703.00)	(266,636,230.40)
Бараа материал худалдан авахад төлсөн	(754,029,642.34)	(620,412,610.00)
Ашиглалтын зардалд төлсөн	(135,814,015.79)	(178,985,488.14)
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	(71,835,600.00)	(153,012,677.58)
Хүүний төлбөрт төлсөн	(1,503,025.00)	(34,106,200.00)
Татварын байгууллагад төлсөн	(385,047,377.21)	(227,775,475.45)
Даатгалын төлбөрт төлсөн	(6,672,443.84)	(1,050,464.50)
Бусад мөнгөн зарлага	(52,458,230.00)	(59,481,470.46)
<u>1.3 Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</u>	<u>216,290,958.31</u>	<u>110,117,010.87</u>
2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
<u>2.1 Мөнгөн орлогын дүн</u>	<u>90,907.98</u>	<u>16,417,441.60</u>
Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого		16,200,000.00
Бие бус хөрөнгө борлуулсаны орлого		
Хөрөнгө оруулалт борлуулсаны орлого		
Бусад урт хугацааат хөрөнгө борлуулсаны орлого		
Бусдад олгосон зээл мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
Хүлээн авсан хүүний орлого	90,907.98	217,441.60
Хүлээн авсан ногдол ашиг		
<u>2.2 Мөнгөн зарлагын дүн</u>	<u>(444,799,465.35)</u>	<u>(16,442,500.00)</u>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	<u>(444,799,465.35)</u>	<u>(16,442,500.00)</u>
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
Бусад урт хугацааат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
<u>2.3 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</u>	<u>(444,708,557.37)</u>	<u>(25,058.40)</u>
3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
<u>3.1 Мөнгөн орлогын дүн</u>	<u>379,900,000.00</u>	<u>-</u>
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	379,900,000.00	

Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас
хүлээн авсан
Төрөл бүрийн хандив
Ханшийн зөрүү

<u>3.2 Мөнгөн зарлагын дүн</u>	<u>(140,519,020.00)</u>	<u>(119,000,000.00)</u>
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	(37,000,000.00)	(119,000,000.00)
Санхүүгийн түрээсийн төлбөрт төлсөн		
Хувьцаа буцаан худалдан авхад төлсөн		
Ногдол ашиг төлсөн	(103,519,020.00)	
<u>3.3 Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</u>	<u>239,380,980.00</u>	<u>(119,000,000.00)</u>
<u>Валютын ханшийн зөрүү</u>	<u>912,467.50</u>	<u>(1,999,664.22)</u>
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	11,875,848.44	(10,907,711.75)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	<u>12,070,479.29</u>	<u>23,946,327.73</u>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	<u>23,946,327.73</u>	<u>13,038,615.98</u>